



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол-Өргөө дотуур байрны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

СБА-2022/99/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор:

Утас: 70512127

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Б.Ариунзул

Цахим хаяг: Ariunzulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	Error! Bookmark not defined.
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Зөвлөмж.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠒.᠒5 № ᠖4

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН БОЛОВСРОЛ-ӨРГӨӨ
НЭГДСЭН ДОТУУР БАЙРНЫ ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.БЯМБАЖАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол-өргөө нэгдсэн дотуур байрны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол-өргөө нэгдсэн дотуур байрны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31,309,966.00</u>	<u>36,579,867.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	31,309,966.00	36,579,867.00
351	Түүхий эд материал	842,699.00	773,400.00
35130	Эм боох материал	842,699.00	773,400.00
354	Хангамжийн материал	30,467,267.00	35,806,467.00
35410	Бичиг хэргийн материал	170,000.00	170,000.00
35420	Аж ахуйн материал	60,800.00	1,296,600.00
35450	Барилгын засварын материал	164,500.00	400,000.00
35460	Хүнсний материал	00.00	1,725,700.00
35470	Бусад хангамжийн материал	30,071,967.00	32,214,167.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,093,378,998.80</u>	<u>2,044,039,329.17</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,093,378,998.80	2,044,039,329.17
392	Биет хөрөнгө	2,035,618,998.80	1,986,279,329.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,047,730,823.01	2,047,730,823.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,423,819.12	-122,135,728.68
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,328,660.17	86,323,160.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,606,861.38	-60,967,914.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,700,230.00	92,007,999.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,510,033.88	-57,079,009.92
39217	Ном	400,000.00	400,000.00
393	Биет бус хөрөнгө	57,760,000.00	57,760,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	58,420,000.00	58,420,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-660,000.00	-660,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,124,688,964.80</u>	<u>2,080,619,196.17</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,124,688,964.80</u>	<u>2,080,619,196.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,124,688,964.80	2,080,619,196.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	86,640,000.00	86,640,000.00
51101	Өмч: - төрийн	86,640,000.00	86,640,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,038,048,964.80	1,993,979,196.17
51210	Өмнөх үеийн үр дүн	2,038,048,964.80	2,038,048,964.80
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-44,069,768.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,124,688,964.80</u>	<u>2,080,619,196.17</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	522,420,500.00	480,350,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	451,374,800.00	383,415,400.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	431,444,800.00	383,415,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	431,444,800.00	383,415,400.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	96,934,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	549,979,521.20	524,420,068.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,979,521.20	524,420,068.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	466,337,264.87	518,319,473.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,364,886.60	222,982,207.31
210101	Үндсэн цалин	159,860,553.54	169,773,987.27
210102	Нэмэгдэл	46,570,710.56	38,932,021.60
210104	Урамшуулал	17,933,622.50	14,276,198.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,439,874.07	29,462,135.67
210201	Тэтгэврийн даатгал	19,670,834.96	20,363,537.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,328,299.54	2,337,698.35
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,814,759.18	1,681,351.69
210204	Ажилгүйдлийн даатгал	420,543.70	802,769.19
210205	Эрүүл мэндийн даатгал	4,205,436.69	4,276,779.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,921,416.00	80,782,182.81
210301	Гэрэл, цахилгаан	9,887,720.00	12,316,003.75
210302	Түлш, халаалт	48,608,560.00	57,875,119.49
210303	Цэвэр, бохир ус	3,425,136.00	10,591,059.57
2104	Хангамж, бараа материалын зардал	6,392,680.00	6,257,175.00
210401	Бичиг хэрэг	1,117,350.00	1,328,900.00
210402	Тэвэр, шатахуун	1,395,000.00	1,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,860,000.00	1,389,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	954,180.00	2,029,275.00
2105	Нормативт зардал	74,811,470.00	101,510,984.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,035,520.00	1,009,299.00
210502	Хоол, хүнс	73,315,980.00	99,363,685.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	459,970.00	1,138,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,059,526.00	15,676,950.00
210601	Багаж, техник хэрэгсэл	00.00	3,500.00
210604	Урсгал засвар	5,059,526.00	15,673,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,016,200.00	2,005,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,016,200.00	2,005,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,331,212.20	59,641,938.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,852,012.20	59,641,938.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,642,256.33	6,100,595.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,107,256.33	6,100,595.21
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	83,107,256.33	6,100,595.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-27,559,021.20	-44,069,768.63
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-27,559,021.20	-44,069,768.63

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,640,000.00	00.00	2,158,534,544.99	00.00	2,245,174,544.99
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-28,880,000.00	00.00	-28,880,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,640,000.00	00.00	2,129,654,544.99	00.00	2,216,294,544.99
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-64,046,558.99	00.00	-64,046,558.99
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,640,000.00	00.00	2,038,048,964.80	00.00	2,124,688,964.80
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,640,000.00	00.00	2,038,048,964.80	00.00	2,124,688,964.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	86,640,000.00	00.00	2,038,048,964.80	00.00	2,124,688,964.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-44,069,768.63	00.00	-44,069,768.63
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	86,640,000.00	00.00	1,993,979,196.17	00.00	2,080,619,196.17

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	502,490,500.00	480,350,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	431,444,800.00	383,415,400.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	431,444,800.00	383,415,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	431,444,800.00	383,415,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	71,045,700.00	96,934,900.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	96,934,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	492,660,610.00	480,350,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,660,610.00	480,350,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	409,018,353.67	474,249,704.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,364,886.60	222,982,207.31
210101	Үндсэн цалин	159,860,553.54	169,991,021.62
210102	Нэмэгдэл	46,570,710.56	38,714,987.25
210104	Урамшуулал	17,933,622.50	14,276,198.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,439,874.07	29,462,135.67
210201	Тэтгэврийн даатгал	19,670,834.96	20,363,537.13
210202	Тэтгэмжийн даатгал	2,328,299.54	2,377,938.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,814,759.18	1,779,490.63
210204	Ажилгүйдлийн даатгал	420,543.70	539,786.28
210205	Эрүүл мэндийн даатгал	4,205,436.69	4,401,383.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,921,416.00	80,782,182.81
210301	Гэрэл, цахилгаан	9,887,720.00	12,316,003.75
210302	Түлш, халаалт	48,608,560.00	53,208,121.06
210303	Цэвэр, бохир ус	3,425,136.00	15,258,058.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,681,852.00	7,217,414.00
210401	Бичиг хэрэг	1,154,800.00	702,050.00
210402	Тээвэр, шатахуун	1,395,000.00	1,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,860,000.00	1,103,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,715,930.00	3,902,364.00
2105	Нормативт зардал	76,471,199.00	103,804,475.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,834,049.00	940,000.00
210502	Хоол, хүнс	73,078,580.00	101,516,475.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	558,570.00	1,348,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,978,026.00	26,698,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	10,754,490.00
210604	Урсгал засвар	4,978,026.00	15,944,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,016,200.00	1,807,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,016,200.00	1,807,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,144,900.00	1,494,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,144,900.00	1,494,450.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,642,256.33	6,100,595.21
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	83,107,256.33	6,100,595.21
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсрол-Өргөө дотуур байр нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-аас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол-Өргөө дотуур байрны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсрол-Өргөө дотуур байр нь Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг орон байраар хангах үйл ажиллагаа үндсэн чиг үүрэг бүхий байгууллага юм.

Боловсрол-Өргөө дотуур байр нь " Эрдэм боловсролтой Эрүүл бие бялдартай Зөв харилцааг эрхэмлэсэн Иргэн болж төлөвших " зорилго дэвшүүлэн ажиллажээ

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол-Өргөө дотуур байр нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 524.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувь буюу 5.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Боловсрол-Өргөө дотуур байр нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 44.0 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Бараа материал	31.3	36.5	5.2
Үндсэн хөрөнгө	2,093.3	2,044.0	49.3
Нийт хөрөнгө	2,124.6	2,080.6	-44.0
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,124.6	2,080.6	-44.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,124.6	2,080.6	-44.0

Бараа материалын дансны үлдэгдэл 36.5 сая төгрөг болж 5.2 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,044.0 сая төгрөг болж 49.3 сая төгрөгөөр буурсан байна. Төсвийн хөрөнгөөр 10.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл худалдан авсан байна.

Боловсрол-Өргөө дотуур байрны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 480.8 сая төгрөг буюу 7.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс

материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын данс байна. Тодруулбал тайланд онд өмнөх оны үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байхгүй байна.

Нийт зардал өмнөх оноос 524.9 сая төгрөг буюу 4.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл, АО-оос НД шимтгэлийн зардал, урсгал зардал, томилолтын зардал, бараа ажил үйлчилгээний бусад зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 520.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 480.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийг 480.3 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 520.0 сая төгрөгийн төсөв баталснаас 480.3 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 480.3 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 474.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 474.2 сая төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цалин, тэтгэмжийн зардал 6.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Боловсрол Өргөө дотуур байрны 2021 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 84 хувьтай үнэлэгдсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Боловсрол Өргөө дотуур байрны үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 133, хугацаа хоцроосон 12 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 61.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгөтэй холбоотой зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

Санхүүгийн тайланд аудит хийхэд бусад үндсэн хөрөнгө худалдан авахад 10.3 сая, нормын хувцас 1.3 сая, тэтгэвэр гарсан ажилтны орон тоонд шинээр ажилтанд 1.7 сая төгрөгийн цалин хөлсөнд зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.2, 1.4-д заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 56 ширхэг 48.2 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн

тогтоох", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2-т "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1-д "Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон", "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1. Өгсөн зөвлөмж:

Анхны өртгөө хуримтлагдсан элэгдлээрээ бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийг холбогдох хууль, эрх зүйн актын хүрээнд санал гаргаж, эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

2. Шилэн данстай холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 145 мэдээллийг ил тод байршуулахаас 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Боловсрол Өргөө дотуур байр	2	61.6	-	-	-	-	1	13.5	1	48.2